



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/15

Хэрлэн сум

Зохион байгуулалтын арга  
хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаал, Аймгийн Онцгой комиссын 2 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Коронавируст халдвар (Ковид-19)-ын болон тус халдварын Омикрон хувилбараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор XVII жарны Усан барс жилийн Цагаан сарын баярыг гэр бүлийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэхийг аймгийн нийт иргэдэд уриалсугай.

2. Сар шинийн баярыг тохиолдуулан нийтийг хамарсан бүх төрлийн золголтын арга хэмжээг хориглож, түүнд хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга, төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт тус тус даалгасугай.

3. “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын тохиолдол тасралтгүй нэмэгдэж байгаатай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах, тэмцэх, хариу арга хэмжээ авах, үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдрөөс 2022 оны 2 дугаар сарын 20-ны өдөр хүртэл аймгийн хэмжээнд олон нийтийг хамарсан соёл урлаг, спортын арга хэмжээг хориглож хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Л.Мэндбаяр), Онцгой байдлын газар (хурандаа Ж.Эрдэнэбат), Цагдаагийн газар (хурандаа Д.Батхүү), Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

4. Шашин, сүм хийдийн үйл ажиллагаа, хурал, зөвлөгөөн, сургалтыг цахим болон танхимын 50 хүртэлх хувийн дүүргэлттэйгээр зохион байгуулж, дархлаа сэргээх нэмэлт 3 дугаар тунд хамрагдсан эсэх, заал танхимын дүүргэлт, халдваргүйжүүлэлт, хариуцлагын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт, Улсын онцгой комиссын 41 дүгээр тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг төрийн болон хуулийн этгээдийн дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

5. Коронавируст халдвар батлагдсан өвчтөнд заавар зөвлөгөө өгч, байнгын хяналтад байлган түргэвчилсэн оношлуур, эм эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлж, тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг ханган, эмнэлэг дэлгэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Л.Мэндбаяр), бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

231010141

2.

6. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт 3, 4 дүгээр тунгийн дархлаажуулалтад иргэдийг хамруулах арга хэмжээг эрчимжүүлж, тухай бүрт мэдээллээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Л.Мэндбаяр), бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7. Төрийн байгууллагуудын 0-5 насны хүүхэдтэй эхчүүдэд (ганц бие эцэг) гэрээс ажиллах боломжийг бүрдүүлж, цалин хөлсийг бүрэн тооцож олгохыг бүх шатны Засаг дарга, байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

8. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх сурталчилгааг иргэдэд насны онцлогт тохируулан төрөл бүрийн хэлбэр (ТВ, Facebook, Tik tok, Twitter, Youtube, Instagram, Viber)-ээр бэлтгэн хүргэж ажиллахыг шуурхай штаб хариу арга хэмжээний сургалт сурталчилгааны багийн ахлагч (С.Оюун-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

9. Мал амьтны гоц халдварт өвчний эрсдэл өндөр байгаатай холбогдуулан отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөн, морин уралдаалга, адуучин тэмцээн зэргийг хориглон түүнд хяналт тавьж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

10. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг дарга 2022 оны А/10 дугаар захирамжийн 5 дахь заалтыг хүчингүйд тсоцсугай.

11. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч бөгөөд нэгдсэн шуурхай штабын дарга (Л.Батсайхан), Онцгой байдлын газрын дарга бөгөөд Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Эрдэнэбат) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ